

# ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН НЭГДСЭН ХОЛБООНД ТАВИГДАХ ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛСОН ЖУРАМ

## НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Энэхүү журмын зорилго нь Хороо холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр хамтран ажиллах нэгдсэн холбоонд /цаашид нэгдсэн холбоо гэх/ тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино.

1.2. Монгол Улсад үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн мэргэжлийн нэгдсэн нэг холбоо ажиллана.

## ХОЁР. НЭГДСЭН ХОЛБООНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1. Нэгдсэн холбоо нь Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилгоор үүсгэн байгуулагдсан, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн, оноосон нэр, тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байх.

2.2. Нэгдсэн холбооны гишүүд нь үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх төрийн бус байгууллага эсхүл тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч байх.

2.3. Нэгдсэн холбоо нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа нийт тусгай зөвшөөрөлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч этгээдийн 50-иас доошгүй хувийг гишүүнээр элсүүлсэн байх.

2.4. Нэгдсэн холбоо нь 2-оос доошгүй жилийн хугацаанд үйл ажиллагаагаа тогтмол явуулж, туршлага хуримтлуулсан байх;

2.5. Олон улсын болон бүсийн түвшний ижил төрлийн зорилго бүхий байгууллагуудтай түншлэлийн харилцаа тогтоож, хамтын ажиллагааг хөгжүүлж чадсан байх;

2.6. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөө боловсруулсан мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх техник хэрэгслийн болон боловсон хүчний чадавхтай байх;

2.7. Нэгдсэн холбоо нь дараах зүйлийг дүрэм, журамдаа тусгаж бүх гишүүдийн хурлаар батлуулсан байх:

2.7.1. гишүүнээр элсүүлэхэд тавих шаардлага, гишүүнчлэлийн хураамж, гишүүнчлэлийг түдгэлзүүлэх, гишүүнээс хасах журам;

2.7.2. гишүүд, тэдгээрийн ажилтнуудын үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн дүрэм

2.7.3. гишүүдийн үйл ажиллагаанд хяналт тавих болон гомдол, маргааныг хянан шийдвэрлэх журам;

2.7.4. Нэгдсэн холбооны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам;

2.7.5. гишүүдэд сургалт явуулах, мэргэшлийн ур чадварыг дээшлүүлэхэд

чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах журам.

2.8. Нэгдсэн холбоо нь дараах зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллана:

2.8.1. холбогдох хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм, журмыг мөрдөх;

2.8.2. гишүүдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, тэдгээрийн санал санаачлагыг дэмжих:

2.8.3. үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай хүний нөөцийн шалгуурыг хангах;

2.8.4. мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээлгэх дотоод хяналтын бүтэцтэй байх;

2.8.5. гишүүнчлэлийн хураамжийн зарцуулалтын тайлагнал ил тод нээлттэй байх;

2.8.6. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн нөхцөл байдал, гишүүдийн үйл ажиллагаанд судалгаа, шинжилгээ хийх, гишүүн байгууллагуудад зэрэглэл тогтоох;

#### ГУРАВ. БУСАД

3.1 Нэгдсэн холбоонд тавигдах шаардлага хангагдсан болохыг Хорооны шийдвэрээр тодорхойлж, хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллана.